



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 4/73

Мандалговь


“Оюуны гэгээ” ТББ-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.2, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг “Оюуны гэгээ” ТББ-аар гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах 3,879,200 (гурван сая найман зуун далан есөн мянга хоёр зуун) төгрөгийг аймгийн 2019 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын “Хөтөлбөр арга хэмжээ”-ний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат), гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Түвшинбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010190